

АЙМГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН
2010 ОНЫ БАЙДЛААР

/Дорнод аймаг/

д/д	Сумын нэр	Хэрэглэгчийн үнэлгээ / энэхүү дүн нь нийт санал асуулгад оролцсон иргэдийн бүрэн хангалттай, хангалттай гэж үнэлсэн дүнгээр харуулав/
1.	Баяндун	68.2
2.	Баянтүмэн	65.3
3.	Баянуул	72.0
4.	Булган	79.0
5.	Гурванзагал	73.5
6.	Дашбалбар	87.3
7.	Матад	67.5
8.	Сэргэлэн	67.5
9.	Халхгол	73.2
10.	Хөлөнбуйр	81.5
11.	Хэрлэн	85.6
12.	Цагаан-Овоо	67.2
13.	Чойбалсан	64.5
14.	Чулуунхороот	65.7
15.	Аймгийн дундаж үнэлгээ	72.7

Жич: Тухайн сумын нийт хүн амын насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувиас авсан судалгааны нэгтгэсэн дүнг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

ТӨР ЗАСГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН БОДЛОГО ШИЙДВЭРИЙН ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮНГИЙН ТУХАЙ

Чойбалсан хот

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт, төрийн алба, үйлчилгээний талаар үнэлэлт өгөх зорилгоор аймгийн нийт насанд хүрсэн иргэдийн 5 хүртэл хувийг хамруулан санал, асуулгыг авсан.

Хөдөөгийн буюу төвөөс алслагдсан сумын иргэдээс санал асуулгыг авахдаа аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулдаг нээлттэй өдөрлөгийн үеэр иргэдээс авсан.

Иргэдээс авсан санал асуулгын агуулга нь Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төрийн албаны чанар хүртээмж, төрөөс үзүүлж буюу үйлчилгээний талаар үнэлэлт өгөх зэрэг зорилтуудыг багтаасан.

Санал асуулгад иргэдийн төлөөлөл нийт 3680 иргэн оролцсоноос хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар оролцсон иргэдийн 43.7 хувь нь бүрэн хангалттай, 29.0 хувь нь хангалттай, 10.0 хувь нь хангалттай бус, 8.8 хувь нь хангалтгүй, 7.6 буюу хувь нь мэдэхгүй гэж дүгнэсэн байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний талаар 48.6 хувь нь онц, 24.1 хувь нь сайн, 13,5 хувь нь дунд, 7,5 хувь нь муу, 6,3 хувь мэдэхгүй гэж дүгнэжээ

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаа 45.7 хувь нь бүрэн хангалттай, 27.0 хувь нь хангалттай, 27.3 хувь нь дунд гэж дүгнэсэн байна.

Дээрх санал асуулгын дүнгээс харахад төрийн үйлчилгээний талаарх асуулгад иргэд өндөр оноо өгч байгаа нь сүүлийн 2 жилд аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдад ажиллах ажлын хэсэгт аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагаас төлөөлөн оролцуулан алслагдсан сум, багийн иргэдэд хүрч үйлчлэх боломжийг хангаж өдөрлөг зохион байгуулан ард иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшсэний үр дүн гэж дүгнэлээ.

Сумдад зохион байгуулсан арга хэмжээний талаар удирдлагуудад тухай бүр танилцуулж цаашид хэрхэн ажиллах талаар тодорхой шийдвэрүүдийг гарган зохион байгуулалтын арга хэмжээг авч, чиглэлээ тодорхойлон хэрэгжүүлэх, үр дүнг тооцож ажиллаж хэвшлээ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ